

ҮСХ-ны даргын 2014 оны  
04 дүгээр сарын 11-ний өдрийн  
. . тоот тушаалын I хавсралт

# **ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ**

Улаанбаатар хот  
2014 он

## **Агуулга**

**Нэг.** Нийтлэг үндэслэл

**Хоёр.** Ойлголт, тодорхойлолт, амьжиргааны доод түвшинг тодорхойлох үндсэн зарчим

2.1. Ойлголт, тодорхойлолт

2.2. Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлоход баримтлах үндсэн зарчим

**Гурав.** Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох үндсэн аргууд

3.1. Хэрэглээний сагсыг үндэслэн хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох арга

3.2. Хүн амын амьжиргааны доод түвшинг хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ийг ашиглан тодорхойлох арга

**Дөрөв.** Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох хугацаа

## **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Монгол Улсын Их хурлаас 1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр баталсан Монгол Улсын “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” хуулийн 5 дугаар зүйлд “. . . хүн амын амьжиргааны доод түвшинг хэрэглээний доод хэмжээг үндэслэн Үндэсний Статистикийн газар тодорхойлно” гэж заасны дагуу 1999 оноос эхлэн Үндэсний Статистикийн Хорооноос “Хүн амын амьжиргааны доод түвшин”-г бүсийн ялгавартайгаар жил бүр тодорхойлон зарлаж байна.

Хүн амын амьжиргааны доод түвшин нь нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэмж, хөдөлмөрийн хөлс, нөхөн олговрын хэмжээг тогтоох, төрөөс иргэдэд эд, мөнгөний туслалцаа үзүүлэхэд жишиг үзүүлэлт болон хэрэглэгддэг.

Хүн амын амьжиргааны доод түвшинг тооцох аргачлалыг ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлалтай уялдуулах, олон улсын жишиг аргачлалд нийцүүлэн үндэсний онцлогийг тусгасан нэгдсэн аргачлалаар тодорхойлох шаардлагын үүднээс энэхүү аргачлалыг шинэчлэн боловсруулж байна.

## **ХОЁР. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ ҮНДСЭН ЗАРЧИМ**

### **2.1. Ойлголт, тодорхойлолт**

Монгол Улсын “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” хуулийн 3 дугаар зүйлд зааснаар **хүн амын амьжиргааны доод түвшин** гэж “...хүн амын хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг, хэрэглээний доод хэмжээ гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээ”-г ойлгоно.

Хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хүнсний ба хүнсний бус хэрэглээ гэж хоёр ангилал бөгөөд **хүнсний нэн тэргүүний зайлшгүй хэрэглээ** гэдэгт Монгол Улсын иргэн үндсэн хуулинд заасан эрхийнхээ дагуу эрүүл аж төрөхийн тулд хоногт шаардагдах илчлэгийг хангах хүнсний бүтээгдэхүүний хэмжээг ойлгоно. Эрүүл хүний хоногт шаардлагатай илчлэгийн хэмжээ, хүнсний

бүтээгдэхүүний зохистой харьцааг ЭМЯ-ны харъяа Хоол судлалын төвөөс тогтооно.

**Хүн амын хүнсний бус нэн тэргүүний зайлшгүй хэрэглээ** гэдэгт тухайн хүн жилийн аль ч улиралд өмсөж болох хувцас (жилийн улирал бүрт тохирсон хувцсыг хэрэглэх боломжгүй байж болно), амьдрах байр, гэр ахуйн болон соёл, ариун цэврийн эн тэргүүний шаардлагатай бараа, зайлшгүй хэрэгцээт төлбөрт үйлчилгээг хамруулан ойлгоно.

## **2.2. Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлоход баримтлах үндсэн зарчим**

2.2.1. Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлохдоо дэлхийн улс орнуудад өргөн хэрэглэгддэг хэрэглээний сагс, хэрэглээний үнийн индексийг үндэслэн тооцдог аргыг өөрийн орны онцлог нөхцөлтэй уялдуулан хэрэглэнэ.

2.2.2. Хүн амын амьжиргааны доод түвшинг бүсийн ялгавартайгаар бүсчилсэн хөгжлийн баримт бичигт тусгагдсан бүсээр тодорхойлно. Үүнд:

1. Баруун бүс: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд
2. Хангайн бүс: Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Орхон
3. Төвийн бүс: Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул
4. Зүүн бүс: Дорнод, Сүхбаатар, Хэнтий
5. Улаанбаатар: Улаанбаатар хот хамрагдана.

2.2.3. Хүн амын амьжиргааны доод түвшинг жил бүр тодорхойлно. Тухайн жилийн бараа, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс хамаарч хүн амын амьжиргааны доод түвшинг жилд 1-ээс доошгүй удаа шинэчлэн тодорхойлно.

2.2.4. Хүн амын хүнсний илчлэгийн хэмжээг хүнсний хэрэглээний физиологийн норм, монгол хүний бодит хэрэглээг харгалзан тодорхойлно. Ингэхдээ ЭМЯ-наас тухайн үед мөрдөж буй хүний эрүүл амьдрахад шаардлагатай хоногийн илчлэгийн хэмжээг үндэс болгоно.

## **ГУРАВ. ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ ҮНДСЭН АРГУУД**

### **3.1. Хэрэглээний сагсыг үндэслэн хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох арга**

Нэг хүнд ногдох хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсыг үндэслэн суурь оны амьжиргааны доод түвшинг шинэчлэн тодорхойлно.

1. Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсыг бүрдүүлэхдээ Үндэсний статистикийн хорооноос явуулдаг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны үр дүнд үндэслэнэ.
2. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийн тооцоонд суурь болгосон он нь хүн амын амьжиргааны доод түвшний суурь он болох бөгөөд ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийн тооцооны суурь оныг шинэчлэх тухай бүрт хүн амын амьжиргааны доод түвшний суурийг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны үр дүнд үндэслэн шинэчилнэ.

Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох хэрэглээний сагс, түүнийг тодорхойлох нь:

Суурь оны “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны мэдээллээс нэг хүнд сард ногдох хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсыг бүрдүүлэхдээ олон улсад хэрэглэгддэг “Ядуурлын шугам тооцох үндсэн хэрэгцээний зардлын арга”-ыг ашиглана. Аргачлалын дагуу тооцоог хийхдээ хүний эрүүл амьдрахад шаардлагатай хоногийн илчлэгийн хэмжээг ЭМЯ-наас тухайн үед мөрдөж буй илчлэгийн хэмжээгээр авна.

Одоогоор Монгол хүний эрүүл амьдрахад шаардлагатай хоногт авбал зохих илчлэгийн хэмжээг Эрүүл мэндийн сайдын 2008 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 257 тоот тушаалаар 2500 килокалори гэж тодорхойлсон байна. Энэ хэмжээг ашиглан нэг хүн хоногт 2500 килокалори илчлэгтэй хүнсний бүтээгдэхүүн хэрэглэхэд зарцуулах мөнгөн дүн, түүнд харгалзах хүнсний бус хэрэглээний хэмжээг аргачлалын дагуу тодорхойлно. Дээрх зарчмаар бүс тус бүрийн хувьд нэг хүнд ногдох хэрэглээний хэмжээг тооцож гаргана.

Ингэж тодорхойлсон дүн нь тухайн бүсийн хүн амын амьжиргааны доод түвшний суурь болно.

### **3.2. Хүн амын амьжиргааны доод түвшинг хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ийг ашиглан тодорхойлох арга**

Хүн амын амьжиргааны доод түвшинг ХҮИ-ийг ашиглан тооцохын тулд өмнөх оны амьжиргааны доод түвшинг хэрэглээний үнийн индексээр индексжүүлнэ. Үүний тулд:

1. Өмнөх онд мөрдсөн бүсийн хүн амын амьжиргааны доод түвшний хүнсний болон хүнсний бус хэрэглээг тухайн бүсийн хүнсний болон хүнсний бус бүлгийн хэрэглээний үнийн индекс (нэг суурьтай хэлхээ индекс)-ээр индексжүүлж тооцно.
2. Бүсийн хүнсний болон хүнсний бус бүлгийн хэрэглээний зардлын нийлбэрээр тухайн оны бүсийн хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлно.

### **ДӨРӨВ. ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ ХУГАЦАА**

4.1 Хүн амын амьжиргааны доод түвшний суурь оныг шинэчлэн тогтоох бол тухайн онд мөрдөх амьжиргааны доод түвшинг оны эхний улиралд багтаан тооцож, зарлана.

4.2 Хүн амын амьжиргааны доод түвшинг Хэрэглээний үнийн индексийг ашиглан тодорхойлж байгаа бол тухайн оны эхэнд багтаан тооцож, зарлана.